



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 470

Улаанбаатар хот


### Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.30-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 12 дугаар  
сарын 27 -ны өдрийн 470 дугаар  
тогоолын хавсралт

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ ЖУРАМ

ШТА1200 8833101394 0498449

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын “Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр”-ийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч шимтгэл төлөх, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.26, 21.27-д заасны дагуу цэргийн байгууллагад алба хаасан жилийг энгийн жилд шилжүүлж шимтгэл төлөх, дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан жилийн нэмэгдэл хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос батлан мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин, хөлс орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг шилжүүлэн тооцоход энэ журмыг баримтална.

Хоёр. Шимтгэлийг төлөх, бүртгэх, шилжүүлэх

2.1. Нийгмийн даатгалын байгууллага Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийг тэтгэврийн даатгалд хамруулж шимтгэлийг төлүүлэн, нийгмийн даатгалын мэдээллийн санд даатгуулагч бүрээр бүртгэнэ.

2.2. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч нь нийгмийн даатгалын санд “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл”-өөс баталсан шимтгэлийн хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын санд өөрөө хариуцан төлнө.

2.3. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.26, 21.27-д заасан хугацааны шимтгэлийг холбогдох аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын зохих сангийн дансанд шилжүүлэх бөгөөд тухайн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар (байцаагч) нь шимтгэл төлөлтийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд даатгуулагч бүрээр бүртгэнэ.

2.4. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21.26, 21.27-д заасан хугацааны шимтгэлийг тооцох, шилжүүлэх чиг үүргийг нийгмийн даатгалын байгууллага дараах байдлаар хэрэгжүүлнэ:

2.4.1. аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан жилийн нэмэгдэл хугацаа, цэргийн байгууллагад алба хаасан жилийг энгийн жилд шилжүүлэн тооцсон тооцоолол, ажилласан хугацааны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт, лавлагааны хамт цахим, эсхүл цаасан хэлбэрээр нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ;

2.4.2. нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь холбогдох баримтыг хянаж, тооцооллыг нэгтгэн нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэхэмжлэл хүргүүлнэ;

2.4.3.нийгийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нэхэмжлэлийг хянаж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох дансанд шимтгэлийн мөнгийг тухай бүр шилжүүлнэ;

2.4.4.нийгийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн шимтгэлийн мөнгийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын холбогдох сангийн харилцах дансанд шилжүүлнэ.

#### Гурав.Шимтгэл төлсөн хугацааг сард шилжүүлэн тооцох

3.1.Ажил олгогч цагаар ажилласан, тухайн сарын нийт өдөр бүтэн ажиллаагүй ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур дүнгээр тооцож олгосон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн хугацааг дор дурдсанаар тооцно:

3.1.1.даатгуулагчийн тухайн сарын орлогыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос баталсан цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хувааж тухайн сард ажилласан нийт цагийг тодорхойлно;

3.1.2.даатгуулагчийн тухайн сард ажилласан нийт цагийг 8 цаг (ердийн ажлын өдөрт ажиллах хугацаа)-т хувааж, тухайн сард ажилласан ажлын өдрийг тодорхойлно;

3.1.3.хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин, хөлс авсан сар бүрийн ажилласан ажлын өдрийг энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасны дагуу тодорхойлж, гарсан хугацааг нэмж, тухайн даатгуулагчийн шимтгэл төлсөн нийт хугацааг сар, өдрөөр тодорхойлно.

#### Дөрөв.Бусад

4.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.